



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД:ГНАГ-2024/15-ШТА-НА-ХОА

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:99013699 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: У.Батчимэг

Утас:7043-2545 Цахим хаяг: Batchimegu@audit.gov.mn

Аудитор: Н.Ариунтуяа

Утас:7043-2545 Цахим хаяг:Ariuntuyan@audit.gov.mn

Агуулга

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 5

**Бүлэг 1: Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс
олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ 6**

Аймаг сумдын сонгуулийн хороодын зардлыг бодитой тооцож төлөвлөжээ 6

Аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсүүд 137,587.6 сая төгрөгийн зардлыг
төлөвлөж зарцуулжээ..... 7

**Бүлэг 2: Аймгийн сонгуулийн хороо төсвийг үр ашиг, арвилан
хэмнэлттэйгээр зарцуулаагүй байна..... 8**

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланг нэгтгэн хянаж 9,755.5
мянган төгрөгийн хэмнэлтийг төвлөрүүлсэн байна 9

Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг бүрэн
хэрэгжүүлээгүй байна..... 10

ДҮГНЭЛТ: 11

- **Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс олгох
санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ. 11**

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ 12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ССХ	Сумын сонгуулийн хороо
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийнэ.

Аудитын зорилт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг УИХ-ын холбогдох Байнгын хороонд танилцуулж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Аймаг, сумдын сонгуулийн хороо, УБХ, аймгийн Цагдаагийн газар зэрэг байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд аймгийн ИТХ-ын 41 мандатын төлөө Монгол ардын намаас 41, Ардчилсан намаас 41, Иргэний зориг, ногоон намаас 3, ХҮН намаас 1, бие даагч 4 нэр дэвшигч, нийт 90 нэр дэвшигч аймгийн Сонгуулийн хороонд бүртгүүлж мандатаа авсан байна.

Аймаг сумын хэмжээнд нийт 856 нэр дэвшигч бүртгэгдсэнээс аймгийн ИТХ-н сонгуульд 90, сумын ИТХ-н сонгуульд 766, үүнээс эрэгтэй 619, эмэгтэй 237 нэр дэвшигч байна.

МАН-аас 408, Ардчилсан намаас 408, Иргэний зориг ногоон намаас 3, Иргэний хөдөлгөөний намаас 9, Хүн намаас 1, Бие даагч 27 нэр дэвшигч өрсөлдсөн байна.


Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд Ховд аймгийн хэмжээнд Аймгийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүн 9, Мэдээлэл технологийн багийн бүрэлдэхүүн 5, Сумын сонгуулийн хороо 131, Мэдээлэл технологийн даамал 110, Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 95, Цагдаагийн албан хаагч 91, хэсгийн хороодод ажиллаж байгаа 727 буюу нийт 1223 Төрийн албан хаагч ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн сонгуулийн хороонд 1,137,274.3 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 88,741.6 мянган төгрөг, Цагдаагийн газарт 48,846.0 мянган төгрөг нийт 1,274,861.9 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 1 127 518.8 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлж 9,755.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Бүлэг 1: Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ

Аймаг сумдын сонгуулийн хороодын зардлыг бодитой тооцож төлөвлөжээ

1.1 Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлын хэрэгцээ, шаардлагыг нутаг дэвсгэрийн сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо тэдгээрийн байршил хоорондох зай зэрэг үндэслэн эдийн засгийн ангиллын дагуу сумуудад баталж хуваарилсан байна. 2024 оны аймаг нийслэл, сум, дүүргийн ИТХ-н сонгуулийн санхүүжилтийг дүрслэн харуулав.



1.2 Зардлын хэрэгцээ шаардлагыг тооцохдоо маягт хэвлэх, үнэмлэх хэвлэх, сургалт, бичиг хэрэг, шуудан холбооны зардал, хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардлыг тогтмол байхаар, зардлын хэмжээг тогтоож өгсөн бол хорооны унааны зардлыг газар нутгийн байршил, сонгогчийн тоо гэсэн үзүүлэлтүүдийг харгалзсан байна.

1.3 Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой зардалд Сонгуулийн ерөнхий хорооноос 6 удаагийн албан бичгийн дагуу нийт 1,137,274.3 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс хуваарилжээ.

Хүснэгт №1 Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан зардал

/мян.төгрөг/

№	Зардлын төрөл	Нийт дүн
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,320.00
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	17,183.25
3	МТБ, даамлын сургалт	23,495.50
4	Бичиг хэрэг	14,470.00
5	Шуудан холбоо	17,700.00
6	Унааны зардал	74,480.00
7	Санал авах байр бэлтгэх зардал	25,480.00
8	Сурталчилгааны зардал	20,000.00
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.00
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх зардал	61,890.00
11	Томилолтын зардал	18,508.70
12	Сүлжээний судалгаа хийх зардал	5,514.00
13	Саналын хуудас устгах зардал	100.00
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	8,820.00
15	Санал авах байрны түлшний зардал	9,450.00
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	12,740.00

17	Шуурхай багийн зардал	3,200.00
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал	713,580.80
19	МТБ, даамалын урамшуулал, хоолны зардал	96,488.00
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	4,290.00
21	Болзошгүй зардал	7,644.00
Нийт дүн		1,137,654.25

1.4 Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албанаас батлагдсан санхүүжилтийг хэрхэн зарцуулах талаар “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар”-ыг тухай бүр ирүүлж, тус тайлбарыг үндэслэн аймаг, сум, хэсгийн хороодод хуваарилалтыг хийх, хуваарилсан төсвийг эдийн засгийн ангилал хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар зарцуулахгүй байхыг чиглэл болгосон байна.

1.5 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн нийт санхүүжилтийн 11.7 хувийг аймгийн сонгуулийн хорооны зардалд, 87.4 хувийг 17 сумын 91 хэсгийн хорооны зардалд хуваарилжээ.

Аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсүүд 137,587.6 сая төгрөгийн зардлыг төлөвлөж зарцуулжээ

1.7 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст УБЕГ-аас 88,741.6 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагджээ.

Хүснэгт2		/мян.төгрөг/		
№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Итгэмжлэгдсэн ажилтны цалин	53,460.0	57,915.0	(4,455.0)
2	Нэрсийн жагсаалт хэвлэх, хүргэх зардал	3,863.6	3,863.6	-
3	Нэрсийн жагсаалт хэсгийн хороодод хүргэх зардал	2,140.0	2,140.0	-
4	Сургалтын унаа, хоол, томилолтын зардал	18,018.0	13,863.0	4,155.0
5	Сургалтын цайны завсарлага	1,824.0	1,824.0	-
6	Сонгуулийн ТТ тээвэрлэх ажлын томилолт	1,136.0	1,136.0	-
7	ТТ тээвэрлэх автобусны зардал	8,000.0	8,000.0	-
8	Шуурхай багийн зардал	300.0	-	300.0
Нийт дүн		88,741.60	88,741.60	-

1.8 Аймгийн цагдаагийн газарт ЦЕГ-аас хоолны зардалд 32,616.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 13,230.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 3,000.0 мянган төгрөг нийт 48,846.0 мянган төгрөгийг хуваарилсан байна.

1.9 Цагдаагийн газраас аймаг сумын орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор саналын хуудас хүргүүлэх үеийн хамгаалалтад 19, саналын

хуудас, санал авах төхөөрөмж хадгалах байрны хамгаалалтад 4, хэсгийн хорооны санал авах байрны хамгаалалтад 91, гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийг шалгаж шийдвэрлэхэд 32, сонгуулийн үйл ажиллагааны үед эргүүлд ажиллах 14, шуурхай удирдлагын штабт ажиллах 9, замын хөдөлгөөний зохицуулалтад 8 албан хаагч ажилласан байна.

Бүлэг 2: Аймгийн сонгуулийн хороо төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэйгээр зарцуулаагүй байна.

Сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч аймгийн сонгуулийн хороо нь 29,396.9 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ

2.1 Аймгийн сонгуулийн хороонд СЕХ-оос ирсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороонд 995,036.0 мянган төгрөгийг хуваарилжээ.

2.2 Сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгээгүйгээр ажиллажээ.

2.3 Сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлэн ажилласан байна.

Сумдад олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4: Аймгийн сонгуулийн хорооноос хуваарилсан төсөв

/мян.төгрөг/

Д/д	Сонгуулийн хорооны нэрс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Алтай сумын сонгуулийн хороо	45,422.0	45,422.0	0.0
2	Булган сумын сонгуулийн хороо	63,112.0	63,112.0	0.0
3	Буянт сумын сонгуулийн хороо	58,994.0	58,994.0	0.0
4	Дарви сумын сонгуулийн хороо	60,125.0	60,125.0	0.0
5	Дуут сумын сонгуулийн хороо	42,916.0	42,916.0	0.0
6	Зэрэг сумын сонгуулийн хороо	53,067.0	53,067.0	0.0
7	Манхан сумын сонгуулийн хороо	64,377.0	64,377.0	0.0
8	Дөргөн сумын сонгуулийн хороо	42,906.0	42,906.0	0.0
9	Мянгад сумын сонгуулийн хороо	50,912.0	50,912.0	0.0
10	Мөнххайрхан сумын сонгуулийн хороо	43,713.0	43,713.0	0.0
11	Үенч сумын сонгуулийн хороо	62,117.0	62,117.0	0.0
12	Ховд сумын сонгуулийн хороо	50,887.0	49,712.0	-1,175.0
13	Чандмань сумын сонгуулийн хороо	69,655.0	69,655.0	0.0
14	Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороо	51,095.0	51,095.0	0.0
15	Жаргалант сумын сонгуулийн хороо	120,616.0	120,616.0	0.0
16	Мөст сумын сонгуулийн хороо	54,992.0	54,992.0	0.0
17	Цэцэг сумын сонгуулийн хороо	60,128.0	60,128.0	0.0
18	Аймгийн СЕХ	142,237.9	133,656.5	-8,581.2
Нийт дүн		1,137,274.3	1,127,518.8	-9,755.5

/Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны мэдээ/

2.4 Сонгуулийн Ерөнхий хорооноос Ховд аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан 1,137,274.3 мянган төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэлээр 1,127,518.0 мянган төгрөгийг олгож, зардлыг 9,755.5 мянган төгрөгөөр

хэмнэж, хэмнэлтийг СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 3.9¹-д заасны дагуу СЕХ-ны дансанд төвлөрүүлэн ажилласан байна.

2.5 Аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлын тайланг төрийн сангийн дансны гүйлгээнээс анхан шатны баримт руу тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Аж, ахуй нэгж байгууллагын дансанд 825.9 мянган төгрөг илүү шилжүүлсэн
- СЕХ-ны албан хаагчдад 2200.0 мянган төгрөгийн шатахууныг талоноор бэлэн олгосон, Тус шатахууны талоноор ямар ажил хийж хэрэгжүүлсэн нь тодорхойгүй
- Албан томилолтын тооцоог 400.0 мянган төгрөгөөр илүү тооцон шилжүүлсэн;
- СЕХ-ны гишүүдэд хоолны мөнгө 1035,0 мянган төгрөгийг давхардуулан олгосон;
- СЕХ-нд хуваарилсан төсвөөс 14572.0 мянган төгрөгийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан;
- Аймгийн СЕХ-оо нь дахин сонгууль зохион байгуулахтай холбоотой 4500.0 мянган төгрөгийн урамшуулалт цалинг гишүүдэд давхардуулан олгосон;
- Мянгад сумын сонгуулийн хорооны гишүүдэд олгосон урамшуулалт цалингийн ХХОАТ 864.0 мянган төгрөгийг дутуу тооцон олгосон;
- Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуулийн санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлаас хэсгийн хороодод худалдан авсан 10 сумын 5,425.0 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг бүртгэлд тусгаагүй;
- УБХ-нь хэмнэгдсэн зардлаас удирдлага нь өөрөө өөртөө тушаал шийдвэр гарган 660.0 мянган төгрөгийн цалин олгосон байна.

2.6 Дээрх алдаа зөрчилд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5² дэх заалтын дагуу төлбөрийн акт тогтоолоо.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланг нэгтгэн хянаж 9,755.5 мянган төгрөгийн хэмнэлтийг төвлөрүүлсэн байна

2.7 Аймгийн 17 сумдын сонгуулийн хороо нь сонгуулийн хорооны гишүүнээрээ нягтлан бодогчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлж сумдын сонгуулийн хорооны тайланг хүлээн авч нэгтгэжээ. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 5 Аймгийн сонгуулийн хороо
/мян.төгрөг/

Д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, Протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	1,320	1,320	-
2	Аймаг, сумын сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардал	17,183	17,183	-
3	Мэдээлэлийн технологийн баг, даамлын сургалтын зардал	23,156	23,156	-

¹ Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ

² батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

4	Бичиг хэргийн зардал	14,470	14,470	-
5	Шуудан холбооны зардал	17,700	17,700	-
6	Унааны зардал	74,480	73,022	1,458
7	Санал авах байр бэлтгэх зардал	25,480	25,480	-
8	Сурталчилгааны зардал	20,000	20,000	-
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300	1,300	-
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах хүргэх зардал	61,890	61,890	-
11	Томилолтын зардал /Сонгуулийн дүн тушаах зардал/	18,509	18,509	-
12	Сүлжээний судалгаа хийх зардал	5,514	5,514	-
13	Саналын хуудас устгах зардал	100	100	-
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	8,820	8,820	-
15	Санал авах байрны түлшний зардал	9,450	9,450	-
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	12,740	12,740	-
17	Шуурхайн багийн зардал	3,200	3,200	-
21	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	713,541	706,209	7,332
22	МТБ, даамлын урамшуулал, хоолны зардал	96,488	95,522	966
23	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	4,290	4,290	-
24	Болзошгүй зардал	7,644	7,644	-
НИЙТ ДҮН		1,137,274	1,127,518	9,756

2.8 Сонгуулийн хороонд ажилласан хугацааны хоолны зардлаас нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүйтэй холбоотой хэмнэлт үүсэж төвлөрүүлжээ.

Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна

2.9 Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Ховд аймгийн 17 сумдаар ажиллаж сонгууль зохион байгуулахтай холбоотой хөрөнгийн зарцуулалт болон санал авах байранд ажиллах сертификат авсан төрийн жинхэнэ албан хаагчдыг хамарсан сургалт, арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг өгч ажилласан байна.

2.10 “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10-д сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь сум дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

2.11 Гэтэл Аймаг, сумдын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

- 2.12 Аймгийн Сонгуулийн Хороо нь Сумдын сонгуулийн хороог байгуулж, арга зүйгээр хангах, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөн ажиллахыг зөвлөж, орон нутгийн хурлын сонгуульд оролцох тухай нам эвслийн хүсэлтийг бүртгэх, Мэдээлэл технологийн даамлуудыг баталж, бүх шатны нэр дэвшигчдийг бүртгэх, баталгаажуулах, сонгуулийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг чадавхжуулах, санал тоолох төхөөрөмж, саналын хуудсыг хэвлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулан ажилласан байна.
- 2.13 Аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч 856 иргэнээс 293 нэр дэвшигч хандивын данс нээлгэн хуулийн хэрэгжилтээ ханган ажилласан бол 563 нэр дэвшигч хандивын данс нээлгэн хуулийн хэрэгжилтийг хангаагүй байгаа нь аймгийн СЕХ-ноос Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- 2.14 Аймгийн Сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч, сумдын Сонгуулийн хорооны зарцуулалтыг сумдын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар харьяа төрийн сандаа гарын үсгийн баталгаа гарган төрийн сангийн хяналттайгаар зарцуулалт хийсэн боловч аудитаар материаллаг дүнтэй зөрчил илэрч байгаа нь шат шатны хяналт хангалтгүй байсныг илтгэж байна

Аудитаар нийт 30,596.9 мянган төгрөгийн зөрчил илэрч 6,099.9 мянган төгрөгийн 3 акт тогтоож, 24,497.0 мянган төгрөгийн нэг албан шаардлага тогтоолоо.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

-  Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ.
-  Сонгуулийн хууль, холбогдох журмыг мөрдөн ажиллаж байгаа ч зарим төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэйгээр зарцуулаагүй байна.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ХОВД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО
84000 Ховд, Ховд аймаг
Утас: 7043-2105 Факс: 976-7043-2105

2024. 11. 28 № 81
танай 2024. 11. 27-ны № 445 -Т

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Х.БОЛДБААТАР ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон цаг хугацааны хуваарьт заасан үйл ажиллагааг хуулийн хүрээнд бүх шатны байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага амжилттай зохион байгуулан ажилласан.

Энэ удаагийн сумын ИТХ-ын сонгуулийн дүнгээр 5 хэсэгт санал тэнцэж нэмэлт санал хураалтыг зохион байгуулсан. Үүнтэй холбоотойгоор болзошгүй зардал болон хэмнэгдсэн зардлаас нэмэлт зардлууд гаргаж ажилласан.

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн санхүүжилтийг сум, хэсгийн алслагдсан байдал, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээнд харгалзан, сумдын ирүүлсэн саналд тулгуурлан аймгийн Сонгуулийн хорооны хуралдаанаар хэлэлцэн хуваариласан.

Монгол улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль 69.3 хувийн ирцгээр санал хураалт явагдаж өмнөх сонгуулийн сонгогчийн ирц нэмэгдэж, бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр 408 нэр дэвшигч баталгаажиж бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн тул дээрх тайлбарыг хүргүүлж байна.

Санал авах байр бэлтгэх, нятлан шалгах, сонгуулийн ирц, дүнг нэн даруй дамжуулах, сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, тог цахилгааны найдвартай тасалдалгүй байх үүднээс төлөвлөгдөөгүй ажил гарч, хувийн суудлын авто машин дайчилах, шуудан холбоо, хоол, унаа, шатахууны зардлууд гарсан болно. Үүнтэй холбоотойгоор Сонгуулийн хорооны гишүүдэд 2.2 сая төгрөгийг шатахуун олгосон нь төлбөрийн акт тавигдаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Аж ахуй нэгжрүү илүү шилжүүлсэн зардал, томилолт, давхардуулан олгосон хоолны зардал зэрэг нийт 2.2сая төгрөг, 24.4 сая төгрөгийн 3 зөвлөмжийг тус тус хүлээн зөвшөөрч байна.

ДАРГА



Б.БАЯРСҮХ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР :

Д/д	Саналын дугаар	Тайлбар
1	2.14	Ирүүлсэн нотлох баримтуудаар нотлогдохгүй байгаа тул хүлээн авах боломжгүй

